



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/217

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, сэхээний тасгийн засвар (Булган сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Гурван уулын хишиг” ХХК-тай 389,000,000 (гурван зуун наян есөн сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгож, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

2. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Гурван уулын хишиг” ХХК-ийн захирал (Д.Мягмардорж)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010270

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 30-ны/ний өдрийн
А/217 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	6,428,727	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	6,428,727	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	3,214,364	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	20,000,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	578,585	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 30-ны/ний өдрийн
А/217 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Г.Аавынхүү	Ү.Бямбасүрэн
2	ХАБЭА-н ажилтан	Д.Мягмардорж	
Машин механизмын жагсаалт			
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	5741 БУЛ	Ү.Бямбасүрэн
2	Ачааны автомашин	4286 БУЛ	

--о00о--